



СЭЛЭНГЭ АЙМАГ  
БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/433

Баруун хараа

Түүх соёлын үл хөдлөх дурсгалт  
газрын тооллого зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай" журмын 2.1, 4.2, аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар 19-ний өдрийн А/312 тоот захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг сумын хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын 06-аас 2022 оны 10 дугаар сарын 07-ныг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Тооллогыг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч  
Нарийн бичгийн дарга

Б.Ууганжаргал  
С.Майцэцэг  
Э.Азжаргал  
Г.Ганцогт  
Н.Дэлгэрмаа

Соёлын төвийн дарга  
ОНСТ-ын ажилтан  
Байгаль хамгаалагч  
Хараа багийн иргэн  
Гонир багийн иргэн

3.Түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын ажлыг холбогдох хууль, журмын дагуу удирдамж, төлөвлөгөө гарган үзлэг тооллогыг явуулах, бүртгэл мэдээллийн санг баяжуулах, олон нийтэд сурталчлан ажиллахыг Орон нутаг судлах танхимын ажилтан /С.Майцэцэг/-т үүрэг болгосугай.

4.Орон нутагт байгаа түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт, хууль бус археологийн малталт хийх зэрэг ажлуудад хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч /М.Бумцэнд/-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын /Б.Эрдэнэбаатар/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Р.БАТЖАРГАЛ